

“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр
сарын 25-ны өдөр

№ 24-01

Улаанбаатар
хот

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, “Глобал Монголиа Холдингс” ХК /цаашид “Компани” гэх/-ийн дүрмийн холбогдох хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийн дагуу энэхүү тогтоолын Хавсралт №1-т заасны дагуу Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланг, Хавсралт №2-т заасны дагуу Компанийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталсугай.
2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг, аудитын дүгнэлтийн хамт тус тус Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэх ажлыг Гүйцэтгэх захирал /Бэк Квангюэл /-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:  /КИМ КИ ХЮУН /



“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр
сарын 28-ны өдөр


№ 14-01

Улаанбаатар
хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлагналыг хүлээн авах,
Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг хойшлуулах тухай**

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт, “Глобал Монголиа Холдингс” ХК /цаашид “Компани” гэх/-ийн дүрмийн холбогдох хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн үндэслэлээ тайлагнасныг хангалттай гэж үзсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан Компани нэмж хувьцаа гаргах, нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэх, дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай асуудлыг дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр хойшлуулсугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан “Бусад” гэсэн асуудалд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдээс ямар нэг асуудал хэлэлцүүлэхээр санал гаргаагүй тул “Бусад” гэсэн асуудлыг хэлэлцээгүй болохыг дурьдсугай.

ХУРЛЫН ДАРГА:  /КИМ КИ ХЮУН /

